БАТЛАВ
УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.БАЯРСАЙХАН

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар 15/02525/20

2020 оны 06 сарын 15 өдөр Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий мэдээлэл:

1.1	**Хүсэлтийн дугаар:**	*20-51-000403*
1.2	**Хэрэглэгчийн нэр, регистр:**	*ШИНЖЛЭХ УХААН , ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ Төрийн байгууллага - РД: 9087087,*
1.3	**Хэрэглэгчийн байршил:**	*Улаанбаатар Баянзүрх 6-р хороо, .*
1.4	**Ажил үйлчилгээний зориулалт:**	*Оюутны дотуур байр, уншлагын танхим*
1.5	**Техникийн нөхцөл олгох үндэслэл:**	*1) Газар эзэмших эрхийн 2018-10-18-ны 000440473 тоот гэрчилгээ.* *2) Архитектур төлөвлөлтийн 2019 оны ГБМЗХ2018/11-001 дугаартай даалгавар, батлагдсан эскиз зураг* *3) Нийслэлийн ерөнхий архитектор бөгөөд Хот байгуулалт, хөгжлийн газрын баталсан ерөнхий төлөвлөгөө* *4) УБЦТС ТӨХК-ийн ЗТТ-ийн 2020 оны 04-р сарын зураг төсөлд тодруулга хийсэн тодорхойлолт*
1.6	**Техникийн нөхцөлийн ангилал:**	*Шинэ холболт*
1.7	**Тооцооны бүрэн чадал:**	*340 кВА (тоогоор)* */Гурван зуун дөч/ (үсгээр)*

Хоёр. Холболтын цэг:

2.1	110/35/10 кВ-ын Туул дэд станц, ХБ-25-ын 10 кВ-ын 13хТП-5 А,Б фидерийн ХТП-199 дэд өртөөнөөс ХТП-2233 хоорондох 10 кВ-ын А, Б кабелийг тасалж ижил хөндлөн огтлолтой ижил маркын шинэ кабель шугам холбож шинээр барих ХТП-ийн 10 кВ- ын I ба II секцэнд оруулж гарган тэжээх.
2.2	Оюутны байр, уншлагын танхим, спорт заалны хэсгийг: Хоёр тусдаа секцтэй сэлгэн залгагч рубильник бүхий щит суурилуулан, шинээр барих дэд өртөөний 0.4 кВ талын I ба II секцнээс тус тус кабель шугам татаж тэжээх.

Гурав. Тоолуур, хэмжих хэрэгсэл:

3.1	Дэд өртөөний 0.4 кВ талын ерөнхий оруулгуудад DLMS протоколыг дэмждэг 3 фазын баталгаат, бүрэн электрон тоолуур, гүйдлийн трансформаторыг тусгай хайрцагт суурилуулах.
3.2	Оюутны байрны 0.4 кВ талын ерөнхий щитний оруулгуудад DLMS протоколыг дэмждэг 3 фазын баталгаат, бүрэн электрон тоолуур, ачаалалд тохирсон дифференциал автомат, хамгаалан таслах төхөөрөмж / УЗО/, ачаалалд тохирсон гүйдлийн трансформатор суурилуулах.

Дөрөв. Тусгай заалтууд:

4.1	Олон улсын стандартын шаардлага хангасан, алдагдал багатай 2*400 кВА чадалтай, 10/0.4 кВ- ын хүчдэлийн, хүчдэл тохируулгын 5 шатлалтай трансформатор бүхий дэд өртөөг өөрийн эзэмшлийн газарт шинээр барих.
4.2	Шинээр баригдах дэд өртөөний 10 кВ талын хуваарилах хуваарилах байгууламж нь 10-аас доошгүй ячейк суурилуулсан байх.
4.3	УБЦТС ТӨХК- ийн эзэмшлийн шугам дэд станцад хийгдэх өргөтгөлийн ажил, шилжүүлэн зөөх ажлыг харьяа түгээх төвөөр гүйцэтгүүлэх.
4.4	Техникийн нөхцөлийн дагуу шинээр суурилуулах тоноглолууд, кабель шугам, трансформаторууд нь сүүлийн үеийн байгаль орчинд ээлтэй, дэвшилтэд техник технологи бүхий байх.
4.5	Дэд станцад суурилуулж буй тоноглолууд нь өмнө нь ашиглагдаж байгаагүй шинэ байх, ± 10 %-ийн хүчдэлийн хэлбэлзэлд хэвийн ажилладаг байх.
4.6	Шинээр баригдах дэд өртөө нь УБЦТС ТӨХК-ийн эзэмшлиийн 10 кВ-ын кабель шугамуудыг оруулж гарган тэжээж байгаа тул тус шинээр татагдсан кабель шугамууд нь УБЦТС ТӨХК-ийн үндсэн хөрөнгө болно.
4.7	Төлөвлөж байгаа барилгын талбайд дараах цахилгаан дамжуулах шугамууд байгаа тул батлагдсан зургийн дагуу трасс өөрчлөн зөөх Үүнд: 4.7.1) 10 кВ-ын кабель шугамууд: - 10 кВ-ын 13хТП-5 А,Б фидерийн ХТП199 дэд өртөөнөөс ХТП-3825 хоорондох 10 кВ-ын 1 ширхэг кабель шугам барилгын талбайд ойртсон. - 10 кВ-ын 13хТП-5 А,Б фидерийн ХТП2233 дэд өртөөнөөс ХТП-3825 хоорондох 10 кВ-ын 1 ширхэг кабель шугам барилгын талбайд ойртсон. - 10 кВ-ын 13хТП-5 А,Б фидерийн ХТП199 дэд өртөөнөөс ХТП-3825 хоорондох 10 кВ- ын 1 ширхэг кабель шугам барилгын талбайд орсон тул батлагдсан зураг төслийн дагуу трасс өөрчлөн шилжүүлэн зөөх 4.7.2) 0.4 кВ-ын кабель шугам: - ХТП-2233 дэд өртөөнөөс ШУТИС- ийн оюутны байрны 0.4 кВ- ын 2 ширхэг кабель шугам барилгын талбайд орсон - ХТП-199 дэд өртөөнөөс Аж ахуйн нэгжийн 0.4 кВ- ын 2 ширхэг кабель шугам барилгын талбайд орсон - ХТП-199 дэд өртөөнөөс орон сууцны байрны 0.4 кВ-ын 2 ширхэг кабель шугам барилгын талбайд орсон тул батлагдсан зураг төслийн дагуу трасс өөрчлөн шилжүүлэн зөөх
4.8	Барилгын талбайд орсон, ойртсон УБЦТС ТӨХК- ийн эзэмшлийн бус цахилгаан дамжуулах шугам, тоноглолыг шилжүүлэн зөөх тохиолдолд эзэмшигчээс зөвшөөрөл авах ба бусад инженерийн байгууламж хариуцсан байгууллагуудтай зөвшилцсөн байх.
4.9	Шилжүүлэн зөөсөн болон шинэчилсэн цахилгаан дамжуулах кабель шугам болон бусад тоноглолыг УБЦТС ТӨХК- ийн харьяа түгээх төвд актаар хүлээлгэн өгөх.
4.10	Зөөж шилжүүлэх 10, 0.4 кВ-ын цахилгаан дамжуулах шугамын угсралтын зураг төслийг ЦБД- ийн БД 43-101-03- д ззасны дагуу зай хэмжээг баримтлан гүйцэтгэх.
4.11	Газар шорооны ажил эхлэхээс өмнө УБЦТС ТӨХК- ийн харьяа түгээх төвд хандаж дахин тодруулга хийлгэх, барилга угсралтын ажлын үед хяналт тавиулж холбогдох баримтыг бүрдүүлсэн байх.

Тав. Дор дурдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:

5.1	Шугам, дэд өртөөний "Ажлын зураг төсөл"-ийг тухайн нутаг дэвсгэрийн ерөнхий

	төлөвлөгөө хариуцсан нэгж болон бусад шаардлагатай байгууллагуудтай зөвшилцөн, мэдээллийн санд оруулсан байх, схем холболт, хүчин чадлыг тус компаниар хянуулах.
5.2	Энэхүү техникийн нөхцөлийн дагуу тавигдах шугам, тоноглолууд нь Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн баталсан "Техникийн шаардлагын тодорхойлолт"- ыг хангасан байх шаардлагатай. Техникийн шаардлагын тодорхойлолтыг www.tog.mn хаягаар орж хууль, дүрэм цонхноос үзэх.
5.3	Хүсэлт гаргагч нь шинээр баригдах ХТП- ний 10 кВ- ын гаргалга шугамуудад богино залгааны гэмтэл заагч датчик, хэрэглэх чадалдаа тохируулж чадлын хязгаарлагчийг тус тус суурилуулах. Техникийн тодорхойлолтыг Техникийн бодлого зохицуулалтын хэлтсээс авах.
5.4	Цахилгаан шугам сүлжээнд холбогдох явцад дайрч гарах зам талбай, бут сөөгийг сэргээн засварлах.
5.5	"Эрчим хүчний тухай хууль"- ийн 30.1.13- д заасны дагуу нийтийн эзэмшлийн орон сууцны барилга барьж байгаа учир шинээр барьсан эрчим хүчний дэд станц, шугам, тоноглолыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх.
5.6	Засгийн газрын 2001 оны 263 тоот тогтоолоор батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн заалтуудыг мөрдлөг болгох.
5.7	"Эрчим хүчний тухай" хуулийн 29.1.9 -д заасны дагуу хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж холбох эрхтэй.
5.8	"Эрчим хүчний тухай хууль"-ийн 30.1.8-д заасны дагуу өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдал, засвар үйлчилгээ, баталгаажуулалтыг бүрэн хариуцах ба харьяа түгээх төв болон бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй ашиглалт үйлчилгээний гэрээ байгуулах.
5.9	Түгээх сүлжээнд залгагдах болон залгаатай байгаа хувийн шугам тоноглол эзэмшигч нь өөрийн шугамын урт, тоноглолын хүчин чадлаас хамааруулан тус компанийн харьяа түгээх төвтэй шуурхай ажиллагааны гэрээг байгуулах.
5.10	Хэрэглэгч нь техникийн нөхцөлийн дагуу захиалсан чадлаа бүрэн ашиглаж чадаагүй нь цахилгаан эрчим хүчний хэрэглээгээр нотлогдсон бол олгогдсон чадлын хэмжээг бууруулж дахин техникийн нөхцөл олгоно.
5.11	"Эрчим хүчний тухай" хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу шугам сүлжээний хамгаалалтын зурвас дотор гэр, орон сууц, барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
5.12	Дэд өртөө, щитний газардуулга болон шугам тоноглолын хэмжилт, туршилтыг норм, дүрмийн дагуу хийлгэн холбогдох газраар шалгуулж протокол авсан байх.
5.13	Угсралтын ажлын явцад тус компанийн харьяа түгээх төвөөр хяналт тавиулж, холбогдох баримтыг бүрдүүлсэн байх.
5.14	Цахилгаан угсралтын ажлыг тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллагаар Аюулгүй ажиллагааны дүрэм, Техник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн дүрмийн дагуу гүйцэтгүүлэх.
5.15	Цахилгаан эрчим хүчний тооцоог Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн харьяа хэрэглэгчдэд үйлчлэх төвтэй хийх.

Зургаа. Бусад:

6.1	Энэхүү техникийн нөхцөлийн дагуу холболтыг 1 жилийн хугацаанд хийж гүйцэтгэх бөгөөд энэ хугацаанд цахилгаан сүлжээнд холбогдоогүй тохиолдолд шинээр техникийн нөхцөл авна.

Комиссын гишүүд: Л.Ганзориг

Б.Аззаяа

Т.Мөнхболд

А.Зоригт

Боловсруулсан: П.Дуламжав

БАТЛАВ
УС СУВГИЙН ЗДИРДАХ ГАЗРЫН
ДАРГА Ц.ТӨРХҮҮ

УСУГ– ын Техникийн нөхцөл олгох комиссын
2020 оны 04- р сарын 02-ны өдрийн хурлын
141 тоот протоколыг үндэслэн зөвшөөрөв.

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ № 141 \ 20

1	**Барилга байгууламжийн нэр, зориулалт, байршил**	**ШУТИС-ийн Барилга Архитектурын сургууль,** спорт заал, уншлагын танхим, дотуур байрны 1,9 давхар 2 блок барилга, БЗД 6-р хороо, оюутны 2-р байрны суурин дээр
2	**Нийт усны хэрэглээ:**	Цэвэр усны **– 32,5 м³/хон** Галын усны **– 2,5 л/с** Бохир усны **– 32,5 м3/хон**
3	**Цэвэр усны холболт хийх цэгийн байршил, шугамын диаметр**	21-р сургуулийн баруун талын цэвэр усны шугамын худагнаас эхлэн өөрийн хуучин барилгын шугамыг тооцооны дагуу өргөтгөн шинэчилж холбох, ажлын зургийн явцад зөвшилцөх
4	**Бохир усны холболт хийх цэгийн байршил, шугамын диаметр**	Төвийн бохир усны Ф800 мм-ийн шугамын худагт одоо байгаа шугам сүлжээг өргөтгөн шинэчилж холбох, ажлын зургийн явцад зөвшилцөх
5	**Нэмэлт нөхцөл**	**Бусад шаардлага:** ➢ Ус хангамж, ариутгах татуургын системийн угаалга, шахалт, туршилт тохируулгын ажлын зардлыг зураг төсөвт тусгах. **Ус нөөцлөх сан төлөвлөж угсрах** ➢ Барилгын гадна цэвэр, бохир усны шугам сүлжээний холбох цэгийг өөрчлөх тохиолдолд хүсэлт тавьж хянуулан, хангагч байгууллагын зөвшөөрлөөр гүйцэтгэнэ. ➢ **Холбогдох Хууль, БНбД, стандартыг мөрдөх** ➢ **Гадна шугамын ажлын зургийг ХБХГ-тай зөвшилцөх** ➢ **Стандартын дагуу тос баригч суурилуулах**
6	**Тавигдах шаардлага**	1. Барилгыг "Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай" хуулийн дагуу ***цэвэр усны шугамын тэнхлэгээс 5 метр, бохир усны шугамын тэнхлэгээс 6 метр*** зайд барих 2.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай" хуулийн 15.1.10 –ын дагуу хангагч нь хэрэглэгчийн шугамнаас дамжуулан шинээр хэрэглэгч холбох техникийн нөхцөл олгосон тохиолдолд батлагдсан ажлын зураг, төслийн дагуу дараагийн хэрэглэгчийг холбуулах. 3.Борооны ус зайлуулах шугам сүлжээг тусад нь төлөвлөх, борооны усыг бохир усны шугаманд нийлүүлэхгүй байх. 4.Цэвэр, бохир усны шугамын угсралт, шахалт туршилт, холболтын ажлын явцад ашиглалтын байгууллагын хяналтын инженерийг байлцуулж ил, далд ажлын акт хөтөлнө. 5.Төвийн болон хэрэглэгчийн цэвэр, бохир усны худаг, шугам сүлжээн дээр болон хамгаалалтын бүсэд зам талбай, авто зогсоол, барилгын довжоо, хүүхдийн тоглоомын талбай зэргийг төлөвлөсөн тохиолдолд засвар үйлчилгээ хийх боломжыг бүрдүүлэх, засварын дараахь нөхөн сэргээлтийн ажлыг өөрсдөө хариуцах 6.Техникийн нөхцлийн хүчинтэй хугацаа **2 жил**.
7	**Объект барих дээд газрын шийдвэр:**	➢ Газар эзэмших эрхийн 000440473 тоот гэрчилгээ ➢ ГБМЗХ2018/11-001 тоот архитектур төл-тийн даалгавар
8	**Хэрэглэгчийн нэр, утас:**	ШУТИС-ийн БАС, Утас: 325109, 91916173

141/20 тоот техникийн нөхцлийн схем зураг:

ТАНИХ ТЭМДЭГ

- Шугам сүлжээнд холбогдох барилга
- Ц — Цэвэр усны шугам
- Цэвэр усны худаг
- Б — Бохир усны шугам
- Бохир усны худаг

ТОДОРХОЙЛОЛТ

1	Төлөвлөж буй барилга
2	21-р сургууль
3	Орчны барилгууд
4	Авто зам, талбай

Ус Сувгийн Удирдах Газрын 207 тоот Утас: 70157018- 129, website: http//usug.ub.gov.mn

УСУГ-ЫН ТЕХНИКИЙН НӨХЦЛИЙН ИНЖЕНЕР Ц.ЦЭРЭНДУЛАМ

БАТЛАВ.УБДС ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Г.БАЯРСАЙХАН

УБДС ТӨХК-ийн Техникийн нөхцөл олгох комиссын 2020 оны 5-р сарын 1-ний өдрийн цахим хурлын шийдвэрээр зөвшөөрөв.

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ № 074/2020

1. **Хэрэглэгчийн нэр:** Шинжлэх ухаан технологийн их сургууль
2. **Барилгын мэдээлэл:** Оюутны байр, заал
3. **Хэрэглэгчийн байршил:** Баянзүрх дүүрэг, 6-р хороо, Арслантай гүүрний зүүн урд
4. **Дулааны хэрэглээ:**

Нийт :	**0.49**	**Гкал/цаг**
А.Халаалт	0.30	Гкал/цаг
Б.Хэрэгцээний халуун ус	0.19	Гкал/цаг
В.Салхилуулга	0.00	Гкал/цаг

5. **Холболтын цэг:** 5г магистраль, ДХ5118-Б12 худгаас холболттой өөрийн салаа шугамыг өргөтгөж холбогдох

Шугамын даралт, температурын утга:

А. Холболтын цэг дээр байх түрэлт	6	м
Б. Шугамын статик даралт	36	м.у.б
В. Буцах шугамын даралт	6.4	ата
Г. Гадна агаарын тооцоот температур	-39	^{0} С
Д.Температурын график	135/70	^{0} С

6. **Мөрдөж хэрэгжүүлэх хууль, дүрэм журам**

6.1 Эрчим хүчний тухай хууль

6.2 Засгийн газрын 2020 оны 3-р сарын 18-ны өдрийн 97 тоот тогтоолоор батлагдсан "Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"

6.3 Эрчим Хүчний Зохицуулах Хорооны 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 290 дүгээр тогтоолоор батлагдсан Дулаан дамжуулах, түгээх сүлжээний "Холболтын журам"

6.4 Эрчим хүчний тухай хуулийн 14-р зүйлийн 14.4-т заасны дагуу Эрчим хүч дамжуулах шугам, дэд станц нь төрийн өмчлөлд байна.

6.5 "Эрчим хүчний тухай хууль"-ийн 30 дугаар зүйлийн 30.1.10; 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалтыг мөрдөж өөрийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчийг холбуулах.

7. **Зураг төсөл, төсөв боловсруулахад тавигдах шаардлага :**

7.1 Зураг төслийн үндсэн шаардлага

7.1.1 "Эрчим хүчний тухай хууль"-ийн 33 дугаар зүйл, "Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм"-ийн 1.3 дах заалтыг мөрдөж дулааны төв шугам, салаа болон салбар шугамаас хамгаалалтын зурвасын зайг хангаж барилгыг төлөвлөх. Шугамын хамгаалалтын зурваст тохижилт, зам талбай, зогсоол, бусад байгууламж төлөвлөхгүй байх.

7.1.2 Шугамын трасс сонголт, холболтыг хийхдээ салаа шугам эзэмшигч, шугамын трасс дагуух газар эзэмшигчтэй урьдчилан зөвшөөрөлцөх, бусдын эзэмшил газар шугамын трассыг сонгохгүй байх.

7.1.3 Монгол улсын барилгын норм ба дүрмийн /БНбД 41-02-05/ 10.7-д зааснаар Дулаан хангамжийн хаалттай системийн үед халуун ус ба халаалтын хамгийн их дулааны ачаллын харьцаанаас хамааруулан ус халаагчийн холболтын схемийг сонгох.

7.1.4 Архитектур төлөвлөлтийн даалгавар, эскиз зургийг үндэслэн зураг төслийг хянана.

7.2 Дор дурдсан техникийн даалгаврын дагуу зураг төслийг хийх

7.2.1 Төлөвлөж буй барилгад төвлөрсөн дулаан хангамжийн техник ашиглалтын шаардлага хангасан халаалтын цогц төхөөрөмж суурилуулах.

7.2.2 Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаанд багтаан дулаан хангамжид холбогдох

7.2.3 Барилгын дотор халаалтын системд балансын хаалт, термостат хаалт суурилуулах

7.2.4 Стандартын шаардлага хангасан дулааны тоолуур суурилуулах.

7.2.5 Гадна дулааны шугам болон узелийн тоноглолыг дулааны алдагдлын норм нормативд нийцсэн материалаар техник ашиглалтын шаардлагын дагуу дулаалахаар зураг төсөвт тусгах.

7.2.6 Дулааны шугам сүлжээ авто зам доогуур огтлох нөхцөлд нэвтрэх сувагтай байхаар төлөвлөж зураг төсөвт тусгах.

7.2.7 Дулааны шугамыг барихдаа трассын дагуух тохижилт, нөхөн сэргээх ажлын зардал болон гадна дулаан хангамжийн систем, узель ба дотор системийн угаалт, шахалтын туршилт хийх зардлыг төсөвт тусгах.

7.2.8 Улаанбаатар хотын ерөнхий архитектор бөгөөд Ерөнхий төлөвлөгөөний газрын даргын 2020 оны 2 сарын 14-ний өдрийн /ГБМЗХ 2018/11-001 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавар, батлагдсан эскиз зургийг үндэслэв.

8. Техникийн нөхцөлд тавигдах нэмэлт шаардлага:

8.1 Дулааны шугам, тоноглол угсрах, хянах хэмжих хэрэгсэл суурилуулах, дулаалга хийхдээ Техник ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрмийг чанд мөрдөж ажиллах.

8.2 Төлөвлөж буй барилгын дулааны ачааллыг техникийн нөхцөлийн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, өргөтгөлийн барилга нэмж төлөвлөхгүй байх

9. Техникийн нөхцөл олгох шалтгаан

Техникийн нөхцөлийн my.dulaan.mn цахим системд ирүүлсэн материалын дагуу хурлыг цахимаар хийхэд нийт гишүүдийн олонхийн саналаар дэмжигдэв.

10. Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа

Энэхүү техникийн нөхцөл олгосноос хойш 2 жилийн хугацаанд хүчинтэй байна.

ЗӨВШӨӨРСӨН.
ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОХ КОМИССЫН ДАРГА,
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР Б.БАТБАЯР

ХЯНАСАН:
ТХХ-ИЙН ДАРГА Б.ХҮРЭЛМӨНХ

БОЛОВСРУУЛСАН:
ТХХ-ИЙН ИНЖЕНЕР Б.ОЧБАЯР

NETCOM

ӨНДӨР ХУРДНЫ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ

БАТЛАВ
МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ч ЗОЛБАЯР
2020 оны 04 сарын 09

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

2020/04/08

Дугаар: **ТН-В176/2020**

Захиалагч байгууллага: ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

Хэрэглэгчийн нэр: Л БАЯР-ЭРДЭНЭ

Харилцах утас: 325109

1. **Байршил:** БЗД-н 6-р хорооны нутаг дэвсгэрт.
2. **Зориулалт:** Дотуур байр, спорт заалны барилга
3. **Холбооны хэрэгцээ:** /урьдчилсан тооцоогоор/
   Телефон тоо (ширхэгээр) **10 ш**
4. **Техникийн онцгой нөхцөл:** Харилцаа Холбооны Зохицуулах хорооноос олгогдсон үндсэн сүлжээ байгуулах бүрэн эрхийнхээ дагуу холбоожуулах техникийн нөхцлийг зөвхөн МХС ХХК олгох бөгөөд техникийн нөхцөлгүйгээр холбооны бүх төрлийн үйлчилгээний зориулалттайгаар кабель татах болон шилжүүлсэн тохиолдолд уг барилга обьектыг техникийн болон улсын комиссоор хүлээн авахгүй болно.
5. **Техникийн үндсэн нөхцөл**
   5.1. ХШ 4542-ний хүрээний S-B 42-6 худгаас барилга хүртэл 110 мм-н 2 яндантай сувагчлал хийх ба шинээр хийх сувагчлалыг 1,0-1,2 метрийн гүнд суурилуулна.
   5.2. Сувагчлал хооронд худаг суурилуулах зай хэмжээг 120 метрээс хэтрэхгүй байхаар тооцох ба эргэлт болон барилгын оролтонд зайлшгүй стандартын худаг суурилуулна.
   5.3. ХШ 4542-ний 5-р зуутын 9-р аравтыг одоо байгаа сувагчлал болон шинээр хийсэн сувагчлалаар татан барилгад оруулж төгсгелийн төхөөрөмжид холбоно.
   5.4. Уг техникийн нөхцөлд зориулж гр 17/6-н 88,89,90-р хосыг эхний ээлжинд нөөцлөв.
   5.5. Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос олгосон холбооны кабель шугамын угсралт хийх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх шаардлагатай.
6. **Зураг төсөвт зайлшгүй тусгах шаардлагатай технологийн онцгой нөхцлүүд:**
   6.1. Шинээр хийгдэх кабель, шугамын угсралтын ажлын зураг төсвийг зохиохдоо Монгол улсын стандарт MNS 5276:2003, MNS 5279:2003, MNS 5280:2003, MNS 5277:2003 тоот ерөнхий шаардлагууд болон ДБХ-ийн сайдын 1995 оны 127-р тушаалаар батлагдсан зааврыг баримтлан гүйцэтгэх.
   6.2. Хэрэглэгчийн шугамын угсралтын ажил барилгын зураг төсөвт байхгүй болон хийгдээгүй бол захиалагчид мэдэгдэж төсөв зурагт оруулах.
   6.3. Кабелийн хуваарилах хайрцагны байрлалыг хэрэглэгчийн шугамын нягтралын цэгт болон техник ашиглалтын шаардлага хангахуйц байдлаар сонгон суурилуулахаар технологийн норм хэмжээг зааж оруулах.
7. **Угсралтын ажлын үед тавигдах нөхцөл:**
   7.1. Угсралтын ажил эхлэхээс өмнө зураг төсөв техникийн нөхцлийн дагуу хийгдсэн эсэхийг Мэдээлэл холбооны сүлжээ ТӨК-ны УБ Хотын сүлжээний газрын Бүртгэл төлөвлөлтийн тасгаар (Утас: 70112399) хянуулан баталгааг авсан байх.
   7.2. Газар шорооны ажил гүйцэтгэхдээ харъяалагдах тухайн тасгийн ахлах инженер болон инженерээр шалгуулан далд ажлын акт үйлдэж хүлээн авах ажлын актанд хавсаргах.
   7.3. Кабель шугамын угсралт болон газар шорооны ажлыг эхлэхдээ УБ Хотын сүлжээний газрын ерөнхий инженерээс албан есны мэдэгдлийг авч тухайн харъяалагдах тасгийн

ахлах инженерийн хяналтан дор гүйцэтгэнэ.

7.4. Шинээр татсан кабель болон кробканд тэмдэглэгээг бүрэн хийсэн байх.

7.5. Угсралтын ажлын явцад захиалагч ашиглалтын байгуулагатай хамтарч хяналт тавьж угсралтын технологийн шаардлагыг бүрэн хангуулсан байх.

7.6. Хэрэглэгч холбох нөхцлийг бүрдүүлэхийн тулд барилгын дотор монтажийн угсралтыг Монгол улсын стандарт MNS 5471:2005 ерөнхий шаардлагын дагуу хийгдсэн, техникийн актны хамт гадна холбооны угсралтын ажлыг хүлээж авна. Шинээр хийсэн сувагчлалын трассыг Нийслэлийн мэдээллийн санд оруулсан тодорхойлолт бичиг болон CD-г техникийн актны хамт УБ Хотын сүлжээний газарт хүлээлгэн өгнө.

8. Захиалагчид ашиглалтын үед тавигдах шаардлага:

Шинээр хийгдсэн холбооны худаг сув агчлал болон кабель шугам нь хотын телефоны кабель шугамын сүлжээнд холбогдох тул:

8.1. Танай эдэлбэр газарт суурилуулагдсан холбооны сувагчлал болон кабелийн гадны механик гэмтэлээс хамгаална.

8.2. Уг сувагчлалын трассыг цааш нь үргэлжлүүлэх болон шинээр кабель татах боломжийг хангах.

8.3. Худаг сувагчлалд техникийн ашиглалтыг хоногийн ямар ч үед ажил үйлчилгээг шуурхай гүйцэтгэх боломжоор бүрэн хангах.

9. Техникийн нөхцлийг ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ-н Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирлын 2019 оны 03-р сарын 30-ний өдрийн 5/176 тоот албан бичгийг үндэслэн олгов.

10. Угсралтын ажил дууссаны дараа хэмжилт шалгалт хийлгэж тогтоосон журмын дагуу УБ Хотын сүлжээний газарт техникийн актаар хүлээлгэн өгсний дараа сүлжээнд холбох зөвшөөрлийг авна.

11. ЭНЭХҮҮ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ НЬ ОЛГОСОН ӨДРӨӨС ХОЙШ 1 ЖИЛИЙН ХУГАЦААНД ХҮЧИНТЭЙ.

Техникийн нөхцөлтэй танилцсан:
УБХСГ-ын Дарга — Н.МАНДАХБААТАР

Техникийн нөхцлийг хянасан:
УБХСГ-ын Ерөнхий инженер — Н.НАРАНБААТАР

Боловсруулсан :
УБХСГ-ын БТТ-ийн ахлах инженер — Д.БАЛМАА